



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар A/109

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 1.2 дахь заалт аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах журам”-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинэ суурьшлын бүсийн 6,55 км авто замын зураг төсөл боловсруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Ганзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)


Гишүүдэд: Б.Долгорсүрэн (Цаст-Алтай цогцолбор сургуулийн эмч)
Ж.Батлхагва (Төрийн бус байгууллагын төлөөлөл)
Ц.Бат-Эрдэнэ (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Б.Болортуул (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Н.Ганзориг)-д даалгасугай.

8400 03 0903
Tush A/109 Am

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Б.Болортуул)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.БАЯРСҮХ